



ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2009 оны 5 дугаар сар

Замын -Үүдэд байгуулахаар санал болгож буй ТХХТ-ийн логистик паркийн эрэлт хэрэгцээний урьдчилсан дүн шинжилгээг хийж дуусгав

Олон улсын зөвлөх Патрисо Мансилагийн тусламжтайгаар уг төслөөс Замын-Үүд дэх авто замаас төмөр замд, төмөр замаас төмөр замд чингэлэг шилжүүлэн ачих үйлчилгээний үнэ, тарифын урьдчилсан дүн шинжилгээ хийлээ. Гаалийн Ерөнхий газар, Төмөр замын газраас авсан үнэ, тарифын мэдээг ашиглан сүүлийн таван жилийн үйл ажиллагааны сар тутмын мэдээнд дүн шинжилгээ хийж боловсруулсны үндсэн дээр санал болгож буй логистик паркийн "үндсэн" үйл ажиллагааны нэг болох шилжүүлэн ачих үйлчилгээний



орлогын тооцоог урьдчилсан байдлаар гаргав. Мөн Төр, хувийн хэвшлийн түншлэл (ТХХТ)-ийн логистик байгууламжийн орлогын урсгалын 30 жилийн тооцоог янз бүрийн хувилбараар тооцлоо.

Замын -Үүдэд байгуулахаар санал болгож буй логистик байгууламжийн эрэлт хэрэгцээний урьдчилсан дүн шинжилгээний үр дүнг танилцуулах, нотлох, хэлэлцэх зорилго бүхий сургалт семинарыг төслийн зүгээс энэ сард 3 удаа зохион байгуулжээ. Эхний семинарыг 5-р сарын 12-нд Төмөр замын газрын ажилтнуудад, хоёр дахь семинарыг 5-р сарын 25-нд Монголын Тээвэр зуучдын холбоотой хамтран, гурав дахь сургалтыг 5 дугаар сарын 26-нд гаалийн ажилтнуудад зориулан тус тус зохион байгуулсан болно.

2008 онд шилжүүлэн ачих үйлчилгээнээс олсон орлого \$3.8 сая, үүний дотор авто замаас төмөр замд шилжүүлэн ачих

ачилтын орлого \$2.11 сая, төмөр замаас төмөр замд - \$1.56 сая, төмөр замаас авто замд шилжүүлэн ачсаны орлого - \$0.13 сая байв. Гаалийн ерөнхий газраас авсан мэдээний дагуу 2004-2008 онд Замын -Үүдэд шилжүүлэн ачсан чингэлэгтэй ачааны жилийн нийт дүнг зураг 1-д харуулав.

Сүүлийн таван жилд Замын- Үүдэд авто зам, төмөр замд шилжүүлэн ачсан чингэлэгтэй ачааны хэмжээ 3 дахин нэмэгдсэн байна. 2004 онд нийт ачааны хэмжээ 524.292 байсан бол 2008 онд 1.540.539 тонн болж өсчээ. Гэхдээ чингэлэгтэй ачааны хэмжээ нь улирлын чанартай байдгийг статистик мэдээнээс харж болно. Чингэлэгтэй ачааны хэмжээ 5-9 дүгээр сарын хооронд хамгийн өндөр түвшинд байдаг бол 11-2 дугаар сарын хооронд ачааны хэмжээ хоёр дахин буурдаг байна.

Зураг 1: Замын -Үүдэд авто зам, төмөр замд шилжүүлэн ачсан чингэлэгтэй ачааны хэмжээ (тонноор, 2004-2008) ба өсөлтийн түвшин

Он	Жилийн нийт дүн	Өсөлтийн түвшин
2004	524,292	-
2005	585,521	11.7
2006	644,562	10.1
2007	992,183	53.9
2008	1,540,539	55.3

Эх үүсвэр: Гаалийн ерөнхий газраас авсан мэдээ

Эрэлт хэрэгцээний тооцоонд улирлын хэлбэлзлийн нөлөөлөл, Төмөр замын газраас авсан жилийн мэдээний дагуу гаалийн мэдээнд оруулсан зохих засваруудыг оруулсан болно. Зураг 2-т одоо мөрдөж буй холимог ачааны тарифыг үндэслэн гаргасан орлогын өнөөгийн үнэ цэнийг харуулав. Цаашид олж болох орлогын тооцоог уламжлалт аргаар гаргасан боловч логистик парк байгуулах төслийн эцэслэн баталсан төлөвлөгөө болон хамрах хүрээнээс шалтгаалан орлогын хэмжээ нэлээд нэмэгдэж болох юм.

Зураг 2: Замын -Үүдийн Шилжүүлэн ачих байгууламжийн орлогын өнөөгийн үнэ цэнэ- ОӨҮЦ- (30 жилийн концессийн гэрээгээр)

Тооцоо	ОӨҮЦ	ОӨҮЦ
	Хямдруулалтын хувь (12%) сая ам.доллар	Хямдруулалтын хувь (15%) сая ам.доллар
A	50	38
B	39.8	32
C	42.5	33.8
D	45.9	36.0
E	48.4	37.7
F	50.5	38.9

Эрэлт хэрэгцээний тооцооны үр дүнгээс үзэхэд логистик паркийн төсөл нь хувийн хэвшлийнхний оролцоог татахуйц эдийн засгийн үр ашигтай байна. Эдийн засгийн үр ашгийн илүү нарийвчилсан тооцоог ТХХТ-ийн бүтэц, нөхцөл тодорхой болсны дараа гаргах боломжтой.

Замын-Үүдэд орчин үеийн шаардлагыг хангасан шилжүүлэн ачих үйлчилгээ, логистикийн байгууламж байгуулах шаардлагатай гэдэг нь маргаангүй асуудал билээ. Ачааны



үнийн дүнгийн 20 хувьтай тэнцэх алдагдсан боломжийн өртөг болон 5 хувийн шууд бус зардалд үндэслэн тооцвол 5-7 дугаар сарын хооронд долоо хоногийн алдагдсан боломжийн дундаж өртөг \$1.9-\$2.78 сая байх тооцоог эрэлт хэрэгцээний дүн шинжилгээний тайланд тэмдэглэжээ. Шилжүүлэн ачих байгууламжийн дэд бүтэц сул байгаагаас улбаатай энэхүү "нуугдмал зардал" нь Монгол улсын эдийн засагт ноцтой саад тотгор учруулж байгаа төдийгүй энэ байдал нь Дэлхийн Эдийн засгийн форумын 2008 оны дэд бүтцийн зохистой



байдал гэсэн үзүүлэлтээр судалгаанд хамрагдсан 134 улс орноос Монгол Улс 133 дугаар байрт зөвхөн Чад улсын өмнө ороход хүргэж байна.

Монгол Улсын Засгийн газар ТХХТ-ийн бүтцийг бий болгох замаар Замын -Үүдийн логистикийн дэд бүтцийг дээшлүүлэх шийдвэр гаргажээ. Үүний зэрэгцээ логистик төвийн эрэлт хэрэгцээний дүн шинжилгээний тайлан гаргаж буй явдал нь уг байгууламжид шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тодорхойлоход чухал алхам болох юм. Цаашид уг төслөөс холбогдох төрийн байгууллагууд, хувийн хэвшлийнхний оролцоог тодорхойлох, стратегийн хөрөнгө оруулагчийг ил тод, нээлттэй байдлаар сонгон шалгаруулах олон улсын тендерийн баримт бичиг боловсруулахад туслалцаа дэмжлэг үзүүлсээр байх болно. Эрэлт хэрэгцээний тайланг эцэслэн гаргасны дараа ЭЗБШӨЧ төслийн вэбсайтад байрлуулна.

Эрчим хүчний асуудлаар сэтгүүлчдэд зориулсан сургалт семинар хийлээ

Эрчим Хүчний Зохицуулах Газар (ЭХЗГ) Хэвлэлийн хүрээлэнтэй хамтран энэ оны 5 –р сарын 8-нд сэтгүүлчдэд зориулж "Эрчим хүчний салбарын санхүүгийн нөхцөл байдал, тарифын асуудал" сэдэвт хагас өдрийн сургалт семинарыг зохион байгуулж, уг төслөөс хамтран санхүүжүүлэв. Сургалтад 8 сонин, 6 телевиз, 2 радио, 2 сэтгүүлийн газар, МОНЦАМЭ агентлагийн нийт 19 сэтгүүлч- сурвалжлагчид хамрагдаж, эрчим хүчний салбарын өнөөгийн байдал, тариф тогтоолт, бага орлоготой ахуйн хэрэглэгчдийг үнийн өсөлтөөс хамгаалах, эрчим хүчний салбарын зохицуулалт, эрчим хүчний салбарт хувийн хөрөнгө оруулалтыг татах төр, хувийн



хэвшлийн түншлэлийн механизмыг бий болгох боломж зэрэг сэдвүүдээр презентаци тавив. Сургалт семинарын зорилго нь эрчим хүчний салбарын санхүүгийн өнөөгийн байдлын талаар баримтат тулгуурласан мэдээллийг хэвлэлийнхэнд хүргэх, эрчим хүчний салбарын тогтвортой ажиллагааг хангахад хараат бус, бие даасан зохицуулагчийн гүйцэтгэх үүрэг ролийн талаар зөв ойлголтыг өгөхөд оршиж байв.

ЭХЗГ-ын Үнэ, тарифын газрын дарга хатагтай М.Ганчимэг эрчим хүчний салбарын санхүүгийн өнөөгийн байдал "дампуурлын эрмэг дээр" байгааг онцлон тэмдэглээд тарифыг үе шаттайгаар нэмэгдүүлэх үндэслэлийг тайлбарлалаа. ЭХЗГ-аас гаргасан тооцоогоор 2007 онд эрчим хүч үйлдвэрлэх, түгээх найман том компаниудын алдагдал 3.89 тэрбум төгрөг байсан бол 2008 онд 24.41 тэрбум төгрөг болж нэмэгджээ. Урт хугацаанд хуримтлагдсан өрийг хатуу валютын ханшаар төлж байгаа нь алдагдлыг ихээхэн нэмэгдүүлэхэд хүргэж байгаа аж. Зөвхөн ханшийн зөрүүгээс 2008 онд 9.9 тэрбум төгрөгийн алдагдал хүлээжээ.



Хэдийгээр компаниуд хугацаа хэтэрсэн өр төлбөрийг барагдуулах хариуцлага хүлээж байгаа ч хуучирсан тоног төхөөрөмжүүдийг нэн даруй засварлан шинэчлэхэд шаардагдаж буй хөрөнгийн улмаас санхүүгийн алдагдалд орсоор байна. Хэрэглэгчдийг цахилгаанаар тасралтгүй, найдвартай хангахын тулд 170 тэрбум төгрөгийн дэд бүтцийн

хөрөнгө оруулалтыг эрчим хүчний салбарт яаралтай оруулах шаардлагатай байгаа талаар М.Ганчимэг танилцуулав.

Зардлаа нөхөх эрчим хүчний салбарын чадварыг сайжруулахын тулд 2009 оны 7 дугаар сарын 15-аас тарифыг нэмэгдүүлэхээр зэхэж буй талаар ЭХЗГ-ын гурван зохицуулагчийн нэг ноён Р.Мягмар хэвлэлийнхэнд мэдэгдэв. ЭХЗГ-ын үзэж байгаагаар зардлаа нөхөхийн тулд одоогоор нэг квт цахилгаанд төлж буй 68 төгрөгийн тарифыг дор хаяж 80 төгрөг хүртэл нэмэгдүүлэх шаардлагатай юм байна.

Уг сургалт семинарын үеэр "Эрчим хүчний тарифыг хэн тогтоох ёстой вэ?", "Тарифын өсөлтөөс эмзэг бүлгийнхнийг хэрхэн хамгаалах вэ?" гэсэн сэдвүүдээр хэлэлцүүлэг явууллаа. Хэлэлцүүлэгт Монголын Үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны тэргүүн С.Ганбаатар, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийг төлөөлөн хатагтай С.Хажид, УБ Цахилгаан түгээх сүлжээний Төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн дарга ноён А.Жанцанноров болон ЭХЗГ-ын удирдлагууд оролцов. ЭХЗГ улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх нь чухал гэдгийг ноён С.Ганбаатар цохон тэмдэглэлээ.

Долоон сонины сурвалжлагчид сургалт семинарын үеэр олж авсан мэдээлэл, мэдлэгтээ тулгуурлан эрчим хүчний тарифын асуудлаар ярилцлага, нийтлэл гаргаж, телевизийн 5 сувгаар уг сургалт семинарын тухай мэдээлэл, үнэ тарифын талаар хийсэн ярилцлага цацагджээ. Мөн тарифыг нэмэгдүүлэх үндэслэл, хуучирсан тоног төхөөрөмжийг яаралтай шинэчлэх шаардлагатайг олон нийтэд тайлбарлан ойлгууллаа.

Жуумла! Төрийн байгууллагуудын вэбмастеруудад зориулсан Агуулгын удирдлагын системийн сургалт болов

Энэ оны 5 –р сарын 19 ба 26-ны өдрүүдэд *Жуумла!* Агуулгын удирдлагын системийн (АУС) сургалтыг Удирдлагын академи дээр тус төслөөс зохион байгуулж, төрийн 4 яам, 21 агентлагийн 25 вэбмастер оролцов. Уг сургалтыг 5-р сарын 18-25-ны өдрүүдэд болсон "Цахим Засаглалын сургалтын долоо хоногийн" хүрээнд зохион байгуулсан юм. Сургалтын явцад нээлттэй эхэд тулгуурласан *Жуумла!* АУС, вэбийн хөгжлийн сүүлийн үеийн хандлага, төрийн байгууллагуудад нээлттэй эхтэй программыг ашиглахын давуу тал зэрэг сэдвээр дэлгэрэнгүй мэдээллийг өглөө.



Үүнээс гадна олон нийтэд зориулсан вэбсайтын серверийн менежмент, оффис пограммын хэрэглээ, сүлжээгээр багаар хамтран ажиллах арга, АУС зэрэг янз бүрийн зорилгоор төрийн байгууллагууд ашиглаж болох нээлттэй эхтэй программын талаар танилцуулав. Иргэдэд шаардлагатай

мэдээллийг вэбсайтад тавьж буйг баталгаажуулахын тулд олон нийтийн санал, хүсэлтийг авч байх нь ач холбогдолтой гэж сургалтанд оролцогчид тэмдэглэлээ.

УБ хотын дулааны хэрэгцээ, хэмнэлтийн тухай телевизийн "Халуун сэдэв" цуврал нэвтрүүлэг

Телевизийн "Халуун сэдэв" цуврал нэвтрүүлгийн хүрээнд уг төслөөс 5 дугаар сарын 4-ний өдрөөс эхлэн долоо хоногийн туршид ахуйн эрчим хүчийг хэмнэх асуудалтай холбоотой телевизийн нэвтрүүлгийг гаргав. Уг нэвтрүүлгийг МҮОНТ-ээр 3 удаа, UBS телевизийн сувгаар 4 удаа давтаж нэвтрүүллээ. Энэхүү нэвтрүүлгийн агуулгыг УБ Дулааны сүлжээ компани ЭЗБШӨЧ төслийн багтай хамтран гаргаж, ивээн тэтгэсэн юм.



Улаанбаатар хотын цахилгаан станц


УБ Дулааны сүлжээ компани нь Улаанбаатар хотод дулаан дамжуулах, түгээх үүрэг хүлээдэг бөгөөд орон сууцны компаниуд хэрэглэгчдийг дулаанаар хангах үйлчилгээг үзүүлдэг билээ. Одоогийн байдлаар УБ Дулааны сүлжээ компанийн ихэнх шугам, хоолой хуучирч, үр ашиг муутай ажиллах болжээ. Дулааны шугам сүлжээний дамжуулах хүчин чадал дээд хэмжээндээ хүрч, хуучирсан, үр ашиг муутай, тоног төхөөрөмж ажиллуулж байгаагийн улмаас ихээхэн хэмжээний усны алдагдалд хүрээд байгаа аж.

Үүний сацуу хотын зарим дүүргийн оршин суугчдаас дулааны системийн хангалтгүй үйл ажиллагааны улмаас өвөл орон сууцанд хүйтэн байна гэсэн гомдол ирсээр байна. Байр, орон сууц хүйтэн байгаагийн хариуцлагыг дулааны сүлжээ компаниуд хүлээх ёстой хэдий ч орон сууц эзэмшигчид, айл өрхүүд үүнд бас хамаатай юм. Оршин сууж буй байраа дулаан байлгах талаар хэрэглэгчид өөрсдөө зохих арга хэмжээ авах нь хөрөнгө санхүү хомс өнөөгийн нөхцөлд халаалтын системийн үр ашигтай хэрэглээнд тус дөхөм болно гэж УБДС ХК үзэж байна.

Оршин суугаа орон сууц, байрны халаалт, дулааны асуудалдаа анхаарал хандуулж, байраа дулаан байлгахад зохих арга хэмжээ авахад нь тус болохын тулд хэрэглэгчдэд холбогдох мэдээллийг хүргэж, тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлж мөн орон сууц эзэмшигчид, сууц өмчлөгчдийн холбоо, ОСНААК болон УБ Дулааны сүлжээ компанийн үүрэг, хариуцлага, гүйцэтгэх үүрэг ролийн талаар зөв ойлголт өгөх нь зүйтэй гэж УБДС компанийн зүгээс онцлож байна.

Гэр орондоо дулаан өвөлжихийн тулд оршин суугчид модон цонхоо вакум цонхоор солих, хуучин паарнуудаа шинэчлэх, тогтмол угаах, тохируулга тавих, ханаа дулаалах зэрэг

өөрсдийн зүгээс авч болох арга хэмжээнүүдийн талаар уг нэвтрүүлгээр дамжуулан зохих мэдээллийг өгөв. Мөн оршин суугчдыг байрныхаа СӨХ-тэй холбоотой байж, орон сууцныхаа шугам сүлжээг засварлан шинэчлэхэд хөрөнгө оруулалт хийхийг шахаж шаардаж байхыг уриаллаа. Үүнээс гадна илүү үр ашигтай ажиллахын тулд дэд станцуудын тоног төхөөрөмжүүдийн хэвийн ажиллагааг хангахад ОСНААК-ын гүйцэтгэх үүрэг ролийн талаар хэрэглэгчдэд мэдээлэл өгсөн болно.



Орон сууцны пааранд суурилуулах тохируулга

Анхны нэвтрүүлэг цацагдсаны дараа гэр орноо хэрхэн дулаалах, ямар арга хэмжээ авах талаар зохих мэдээлэл авсан хэрэглэгчид УБДС компанид санал бодлоо илэрхийлжээ. Хэрэглэгчдийн санал хүсэлтэд үндэслэн УБДС компаниас нэвтрүүлгийг дахин дамжуулах хүсэлт гаргасны дагуу ЭЗБШӨЧ төслөөс 6 дугаар сарын эхээр нэвтрүүлгийг дахин дамжуулахаар төлөвлөөд байна. Телевизийн "Халуун сэдэв" цуврал нэвтрүүлгийн "УБ хотын дулааны хэрэгцээ ба хэмнэлт" нэвтрүүлгийг уг төслийн вэбсайтын (www.eprc-chemonics.biz) "Multimedia" хэсэгт орж үзнэ үү.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтээ ЭЗБШӨЧ төслийн цуврал хариуцсан эрхлэгчид дараахь хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@eprc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.